



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.12 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн дүгнэлтийн дагуу Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хуулийн этгээд (2)-ийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл шинээр олгосон хуулийн этгээдтэй хуульд заасан хугацаанд гэрээ байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн
102 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, үйлчилгээний хүртээмж	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Дуусах хугацаа
1	"Велокс бие инженеринг" ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх	5 жил	2031.08.13
2	"Зөв замнал ирээдүй" ХХК	Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх	5 жил	2031.08.13

----- оОо -----